

## НАГ, Х-1, Д-1, ХН-110

### ЖИНХЭНЭ ЦЭРГИЙН ЯДУУ ГЭРТ ТЭТГЭВЭР ОЛГОХ ДҮРЭМ

Монгол ард улсын жинхэнэ цэргийн албанаа татан ирүүлсэн хүмүүсийн гэр ядууд тусламж үзүүлэн тэтгэвэр олгох тухай дүрэм

**НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.** Аливаа жинхэнэ цэргийн албанд томилогдсон хүмүүсийн гэрийн газар амин олжих хөрөнгө чинээ огт үгүй аж төрөн амьдрах аргагүй буюу зөвхөн амин олжих хөрөнгө бүхий боловч түүнийг ачлан яадах ам бүлгүйг ялган салгаж тус тус тусламж үзүүлэн тэтгэвэр олох зэрэг явдлыг энэхүү дүрмийн ёсоор дагаж шийтгүүлвээс зохимуй.

**ХОЁРДУГААР ЗҮЙЛ.** Жинхэнэ цэргийн албанаа томилогдсон хүмүүсийн гэрийн газар тусламж үзүүлэн тэнхрүүлвээс зохигчдыг таван зэрэг болгон ялган салгаваас зохих учир

- Нэгдүгээр зэргэд ажил хийж чадах нэг хоёр байваас хөрөнгө хогшил ба огт малгүй болмуй
- Хоёрдугаар зэргэд ажил хийж чадах хүн нэгийн датуй буй ба үгүй боловч ам бүрд хошууд бод үл хүрэх цөөн малтай гэр болмуй
- Гуравдугаар зэргэд ами тэжээж хүрэлцэх зөвхөн хүрээгүй боловч ажил хийж чадах хүн огт үгүй гэр болмуй
- Дөрөвдүгээр зэргэд ам бүрд хошууд бод мал үл хүрэх боловч аж ахуйд чадамгай хүн бүхий бөгөөд амь зуух идэх өмсөх зэргэд зөвхөн хүрэлцэх гэр тооцвоос зохимуй
- Тавдугаар зэргэд ажил хийж чадах ба үл чадах боловч хэзээний айлд оршин сууж идээшлийг олж амь зуух хүмүүс болмуй. Үүнд тайлбарлал тэмдэглэх нь НЭГ. Хамт нэгэн гэрт суух бөгөөд хөрөнгө ажил нэгтээ ойр ураг төрлийн хүмүүсийг нэг гэрийн хүмүүс хэмээмүй.

ХОЁР. Ажил хийж чадах хүмүүст бие эрүүл тахир дутуугүй 16 наснаас 55 нас хүртэлх эр хүмүүс, 16 наснаас 45 нас хүртэлх бүсгүйчүүдийг тоолвоос зохимуй.

ГУРАВ. Нүд сохор гар хөл тахир дутуу, архаг өвчинд тохиолдсон, хөгшин ба 16 насанд хүрээгүй хүмүүсийг цөм ажил хийж үл чадах хүмүүст тооцмуй

ДӨРӨВ. Уул цэргийн албанаа томилогдсон хүн гэрийн ам бүлийн ажлыг хийж тэтгэн явсан ба үгүй болвоос нэгэн данстай хамт оршиж байсан болвоос ялгаварлан хэлэлцэх зүйлгүй амуй.

ТАВ. Хэдий нэгэн данстай боловч тэтгэн явсангүй агаад мөн хамт оршиж байсангүй агаад ялгавар учрыг тодорхой мэдэх аваас тухайд арван гэр сум багийн дарга нар учир үнэн магадыг хянаж хошууны хуралд мэдүүлэн хянан хэлэлцэж магадлан тогтоолговоос зохимуй.

**ГУРАВДУГААР ЗҮЙЛ.** Жинхэнэ цэрэгт томилогдсон хүмүүсийн гэрийн хүмүүс хэдий ядуу хэмээвээс ам бүр хошууд бод малын тоонд хүрэх мал буй аваас тэтгэвэр тэжээл олгуулахыг хэрэгсэхгүй болгохоос гадна ган зуд гамшгийн зэрэг аюул тохиолдож орон нутгийн айл хүмүүс өөр газар нүүн одох хэрэг буй болж хянан магадлаж тусламж үзүүлэн хамтаар нүүлгэн аваачваас зохимуй.

**ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.** Жинхэнэ цэргийн албанаа томилогдсон хүний үлдсэн

1. Нэгдүгээр зэргийн ядуу гэрт ам бүрт хошууд бод малын тоонд тохирох үржил бүхий жижиг мал ба мөн хувцас зүйлийг зохисоор олгож тэжээн тэнхрүүлвээс зохино.

2. Хоёрдугаар зэргийн ядуу гэрт ам бүл бүрт хошууд бод мал үл хүрэх мал байх аваас чухам дутагдсан нь хэд болохыг харьяат арван гэрийн дарга үнэн магадыг хянаж улам улмаар магадлуулан мөн дутууг үржил бүхий жижиг малаар олгож тэтгэмжилвээс зохимуй.
3. Гуравдугаар зэргийн ядуу гэр амь тэжээж зөвхөн хүрэлцэх хөрөнгө хогшил мал буй боловч ажил хийж чадах хүн огт үгүй нь үнэн аваас тус аравны гарын дотор ажил ахуй мал адгуус нутаг үндсийг мэдэх шударга үнэнч сайн хүмүүст түшүүлэн тэтгэмжлүүлж тэнхрүүлвээс зохино.
4. Дөрөвдүгээр зэргийн ядуу гэрт аж ахуйд чадамгай хүмүүс буй агаад мал нь ам бүрт хошууд бод үл хүрэх боловч амь зуух идэх өмсөхөд гачигдалгүй болвоос энэ удаа тэтгэвэр олгуулахыг хэрэгсэхгүй болговоос зохих тул арван гэрийн даргад магадлал мэдүүлж баг сумын дарга нараас ингэж аж төрөн чадах байдал үнэн ташааг магадлан үзэж улмаар хошууны газар мэдүүлэн хошууны хурлаар хэлэлцүүлэн хянан магадлуулж тогтоолговоос зохихын гадна хэрэв сүүлийн өдөр гачиг тохиолдох аваас зохихоор тусламж үзүүлэн тэтгэвээс зохимуй.
5. Тавдугаар зэргийн хэзээний айлд оршин сууж идээшлийг олсон өмсөх идэх хүрч болоцсоор ирсэн ядуу эр ба бүсгүйчүүд ганц бие боловч ах дүү ураг төрөл нэг хоёр хэд боловч тэтгэвэр авахыг үл дурлах нь хааяа байх аваас арван гэрийн дарга түүний хамтаар сум баг хошууны цэргийн хэлтэсд орж батлуулан нэг удаа дураар болгон явуулж гагцхүү сүүлийн өдөр бие өвдөх буюу нас өтлөх зэргээр амь зуун чадахгүйд хүрч ирэхгүйд аль тохиолдсон газар газраас түүний биеийг уул арван гэрийн даргад хүргүүлэн өгч мөн арван гэрийн дарга шууд хүлээн авч арван гэрийн нэгэнд агуулан суулгаж ёстой тусламж үзүүлэн эмчлүүлэн сувилуулах ба хувцас хоол хүнс зэргийн тэтгэвэр олгуулан тэжээн тэнхрүүлвээс зохимуй. Үүнд тайлбарлах нь,
  1. Ажил хийж чадах хүн нэг хоёр буй боловч тэд нар угаас яахан ажил хийж амьдрахыг эс хичээсэн
  2. Юу буйгаар архи дарс уух буюу даалуу хөзөр зэргийн наадам наадаж сүйтгэдэг ба, эсэх
  3. Эс бөгөөс зөвхөн буйг эзэрхэн ганц биеийг тэжээн өмсөх зэргэд хэрэгсээд амраар сул сууж бусдыг гачигдуулсан зүйл буй үгүй
  4. Бусад хөрөнгөтөн эрхтэнд тэдний ажил явдалд хугасаар зарцуулагдан гэрийг тэнхрүүлж үл чадсан
  5. Одоогийн тэтгэмжлэл олгуулсан мал юмыг үнэн санаагаар асрамжлан ажиллаж үржүүлэн амь олжиж тэнхрэхийг хичээж буй үгүй
  6. Одоогийн олгосон мал юмыг ганцаар эзэрхэх буюу шийтгэх зэргийг харьяат арван гэр сум баг хошууны цэргийн хэлтсийн дарга нар хянан ажиглаж ажил явдлыг сайжруулан тэнхрүүлэхийг хичээн сургаж тусламж үзүүлвээс зохимуй.
  7. Хэрэв хажуу явдал буй болж үнэн магад илэрвээс хошууны цэргийн хэлтэсд мэдүүлж улмаар магадлал хууль дүрмийн ёсоор цээрлүүлэн шийтгүүлвээс зохимуй
  8. Энэхүү олсон тэтгэвэр мал болвоос жинхэнэ ардын цэргийн албанаа дайралдагсдыг чухал болгон үзэж ядуу ам бүлийн гачигдлыг арилган тэнхрүүлэхийн учир тэтгэвэр олгосон зүйлийг зүй бусаар сүйтгэж үрэгдүүлвээс хэрхэвч үл болмуй
  9. Таван зэргийн ядуу гэрийн ардад тэтгэвэр олгож тусламж үзүүлэхэд арван гэрийн даргаас харьяат арван гэрийн дотор үнэхээрийн тэтгэвэр олговоос зохих ядуу

- гэрийн хэн хэн хэд хэдэн настай бүгд хэдэн ам бүл буй хөрөнгө хогшил мал адгуус юутай зэргийг нарийвчлан хянаж хэддүгээр зэргийн ядуу гэрт тооцвоос зохих зэргийг тайлбарлан тодорхойлж багийн даргад мэдүүлэн сум багийн дарга нараас дараалан үнэн магадыг хянаж уламжлан хошууны тамгын газар мэдүүлэн хошууны хуралд хэлэлцүүлэн үнэн магадыг дахин сайтар хянаж батлуулсны хойно бүх хэчнээн хүнд хэдий чинээ тэтгэвэр мал юм олгуулах явдлыг төсөвлөн хошууны нийт албаны хувиарт нийгэмчлэн хуваан ногуулж \оноох\ олгуулваас зохимуй.
10. Таван зэргийн ядуу ам бүл өвөл зуны улирал ба ган зуд гамшгийн зэрэг аюул тохиолдох аваас ачлага уналгыг арван гэрийн дотроос туслан олгуулж хамтаар нүүлгэн аваачваас зохимуй.
  11. Таван зэргийн ядуу гэр ам бүлээс жинхэнэ цэргийн албанаа томилогдсон хүмүүс хоёр жилийн хугацаа гүйцвээс цэргээс халагдаж гэрт буцах тул мөн олгуулах тэтгэвэрийг хоёр жилийн хугацаагаар нэг удаа бүрмөсөн олгуулж тэдний ядуу гэрийн хүмүүст олгуулсан малыг сайнаар асрамжлан маллаж үржүүлэн харин элбэг дэлбэг болвоос хойч өдөр эгүүлэн хураамуй гэх явдалгүй зөвхөн албан татварыг ногуулан гаргуулваас зохимуй.
  12. Таван зэргийн ядуу гэрийн хүмүүс аж ахуй ба тэтгэмжлэн олгуулсан малыг сайнаар ажиллан маллаж чадах хүмүүс буй атал улмаар хүмүүжин тэнхрэхийг эрхэм болгон чармайхгүй харин хайхрамжгүйгээр үргэдүүлэх буюу аж ахуйг сайжруулж ажил хийхийг хичээхгүй, гажуу санал агуулж биеийн амраар сууж идэж өмсөж барагдуулваас дахин тэтгэвэр олгуулах буйяа хэмээх санаагаар эндүүрэн үзэж бусдаас гэрчлэн гаргах зэргээр үнэн магад илэрвээс хүндээр шийтгүүлвээс зохимуй.
  13. Таван зэргийн ядуу гэрийн хүмүүст онц өвчин гамшиг тохиолдож гачигдах аваас онц тусламж үзүүлвээс зохихын гадна ган зуд усны аюул тохиолдон олгуулсан тэтгэвэр мал сүйтгэгдэн хохирох аваас эл үнэн байдлыг арван гэр сум багийн дарга нар үнэн магадыг хянаж хошууны тамгын газарт мэдүүлэн магадуулж жич энгийн ардыг тэнхрүүлэх зардлын дүрмийн ёсоор тэнхрүүлэн тусламж үзүүлэн тэнхрүүлсэн явдлыг улмаар цэргийн явдлын яамнаа мэдүүлэн хянуулваас зохимуй.
  14. Гуравдугаар дөрөвдүгээр зэргийн ядуу гэрийн хүмүүс хэдий зөвхөн амь олэих мал буй ба аж хийхүйд чадамгай бөгөөд идэхүй өмсөхүйд элбэг хүрэлцмүй хэмээж тэтгэвэр олгуулахгүй боловч харин албан татвар гаргуулж үл болмуй.
  15. Дөрөвдүгээр зэргийн ядуу гэрийн адил ам бүр үл хүрэх мал буй боловч алт мөнгөний үнэхээрийн хөрөнгө бүхий худалдаа арилжааг гүйлгэн үлэмж ашиг олох гэрийн хүмүүсийг адилтгаж үл болмуй.
  16. Жинхэнэ цэргийн албанаа томилогдсон хүн нэг данстай боловч язгуураас нэг хамт оршин сууж ажил хийж ам бүлийгтэтгэн явсангүй тусгай байшин учир ялгавартай нь үнэн бөгөөд олон ард тодорхой мэдэх аваас арван гэр сум багийн дарга үнэн магадыг хянаж улмаар хошууны хурал тамгын газар мэдүүлэн хянуулж эрхгүй энгийн зэрэг ядуу ардыг тэнхрүүлэх дүрмийн ёсоор тэнхрүүлвээс зохимуй.

**ТАВДУГААР ЗҮЙЛ.** Жинхэнэ цэргийн албанаа томилогдсон хүмүүсийн гэрийн зарын хүн нар нэгдүгээр зэргийн ядуу бүсэд тэтгэвэр мал олгуулахад малыг адуулан ажиллаж чадах хүн огт үгүй нь үнэн боловч олговоос зохих малыг хэвээр олгуулан арван гэрийн даргад

ядуу хүмүүсийн хамтаар тулган тушаан өгч арван гэрийн дотор малыг үржүүлэн өмсөх идэхийг гүйцэтгэн хүмүүжүүлэн сувилуулах зэргээр тэтгэмжилвээс зохимуй.

**ЗУРГААДУГААР ЗҮЙЛ.** Харьяат хошуудын цэргийн хэлтсээс эл цэргийн албанаа томилогдогсдын ядуу гэрийн байдал ямар ба тэтгэвэр олгосон нь ёсоор хүрэлцэж болсон эсэх, бас ч буй үгүйг сайтар хянан магадлаж байваас зохимуй.

**ДОЛООДУГААР ЗҮЙЛ.** Арван гэрийн дарга ба сум багийн дарга нар ов мэх зохиож үнэхээрийн тэтгүүр олговоос зохих ядуу ардыг гачигдуулсан буюу оролцвоос үл зохих хүнийг оруулан нуурчилсан зэрэг гэм учир гарваас улмаар цэргийн явдлын яамнаа мэдүүлэн цэргийн сахилга журмыг гачигдуулсан дүрмийн ёсоор хүндэд цээрлүүлэн шийтгүүлвээс зохимуй.

**НАЙМДУГААР ЗҮЙЛ.** Энэхүү дүрэмд дурдсан ядуу гэрүүдэд тэтгүүр зүйлүүдийг хэрхэн гүйцэтгэсэн явдлыг харьяат хошуудын тамгын газраас тухай бүр аймгийн яамнаа мэдүүлж мөн аймгийн яамнаас уламжлан цаг бүрийн эцэст цэргийн явдал яамнаа мэдүүлэн ирүүлвээс зохимуй.

Монгол улсын арван тавдугаар он арван сарын арван зургаан

1925.10.16